



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Ж.ЧИНБҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2025. 11. 20 № 50

Эрүүл мэндийн салбарын  
үйл ажиллагааны талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын эрүүл мэндийн салбарын санхүүжилт, анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмж, гурван шатлалын эмнэлгийн ачаалал, үнэлгээ, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалттай холбоотой асуудал болон эмийн чанар, хяналт, нийлүүлэлт, хуурамч эмийн нөхцөл байдлын талаар Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед улсын төсвөөс зарцуулсан нийт хөрөнгийн хэмжээ, үүнээс вакцинжуулалт, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо зэрэгт хэдэн хувийг зарцуулсан;

2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед 500 орчим тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан нь санхүүгийн эрсдэл үүсгэсэн эсэх, тус зардлыг буцаан санд төлж дууссан эсэх болон Засгийн газраас Эрүүл мэндийн даатгалын сангийн төлбөрийн үүргийг дахин тогтоох, тодорхой болгох асуудлаар хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлого, арга хэмжээ;

3.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гарсан үед авах хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг зөвхөн Засгийн газрын нөөцөөс бүрэн санхүүжүүлэх боломж, шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр байгаа эсэх;

4.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөвт төвлөрүүлэх орлого 2,515 тэрбум төгрөг, зарлага 2,135 тэрбум төгрөг, сангийн нийт зардал (эмчилгээ, эмийн хөнгөлөлт, урсгал зардал, хөрөнгө оруулалт гэх мэт) хэдэн хувиар өссөн, 2022-2023 оны хуримтлагдсан өр 218 тэрбум төгрөг. Энэ өрийг 2025 онд хэрхэн төлөх талаар болон алдагдлыг бууруулах бодлогын хүрээнд шимтгэлийн хэмжээг 2 хувиар нэмэгдүүлснээр гарах үр дүнгийн талаарх тооцоолол бүхий судалгаа;

5.2021 оноос хэрэгжүүлсэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжиж эхэлснээс хойш эрүүл мэндийн байгууллагууд хүндрэлтэй ажиллаж байна. Тогтолцоог сайжруулах талаар авч байгаа арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудыг сонгон шалгаруулах, төлбөр, чанарын шалгуурын журмууд 2022

2025000082

оноос шинэчлэгдээгүй байгаа нь сангийн тэнцэлд доголдол, алдагдал үүсэхэд нөлөөлсөн эсэх;

6.Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 2–3 сараар хоцорч байгаа шалтгаан;

7.Дээрх гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй холбоотойгоор Эрүүл мэндийн төвүүдийн 2025 оны ачаалал, бодит байдалд үүссэн хүндрэл, нөхцөл байдал, нэг иргэнээр тооцсон санхүүжилт анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэмжлэг болж чадсан эсэх;

8.Одоогийн энэ тогтолцоо нь анхан шатны тусламж үйлчилгээний чанар, стандартын дагуу иргэдээ өвдсөн хойно нь бус, өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлж эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх, шатлал хоорондын шилжилт, давхардлын асуудлыг шийдвэрлэж байгаа эсэх талаар;

9.2025 оны 10 дугаар сарын байдлаарх эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь, иргэдийг бүрэн хамруулах талаар авч байгаа арга хэмжээ;

10.Хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулсан 137 тэрбум төгрөгийн зарцуулалт, тавигдсан шаардлагын талаарх мэдээлэл;

11.Эрүүл мэндийн даатгалаар санхүүжүүлэх анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц шинэчлэгдсэн эсэх, шатлал тус бүрд тавигдах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, стандарт, хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулах ажлын явцын талаар;

12.Улсын эмнэлгийн зайлшгүй шаардлагатай шинэчлэх тоног төхөөрөмжийн шинэчлэлт, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжсэн үр дүнгийн талаарх мэдээлэл;

13.Хувийн эмнэлгүүдийн үйлчилгээний чанарын хяналт хэрхэн хийгддэг, хувийн эмнэлэгтэй харьцуулахад улсын эмнэлгүүдийн оношилгоо, эмчилгээний чанарт ялгаа байгаа эсэх.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ц.БААТАРХҮҮ

2025000082